

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АЙМАГ, СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООД БАТЛАГДСАН ТӨСВИЙГ
ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2024/06-22-ШТА-НА

АУДИТЫН НЭР: “СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ”

Чингис хот 2024 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Энх-Амгалан

Утас: 91119424 Цахим хаяг: enkh-amgalang@audit.gov.mn

Аудитор Б.Ариунаа

Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

ГАРЧИГ

1. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Сонгуулийн хороодод төсвийг хууль, журмын дагуу төлөвлөж хуваарилсан байна.	7
1.1.1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын төсвийг журмын дагуу боловсруулж батлуулсан байна.	7
1.1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.	8
1.1.3 Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас бодитой тооцож ирүүлээгүй байна. .	8
Сонгуулийн хороод сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.	9
1.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.	9
1.2.2. Сонгуулийн хороод зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.	10
1.2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	11
2. АУДИТЫН ДҮГНЭЛТ:	12
3. ҮАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	12
4. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:	12

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

**Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийлээ.

**Аудитын
зорилт**

“Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг УАГ-т танилцуулж, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглээдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- *УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх*
- *УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх.*

**Аудитын
хамарсан
хүрээ**

Аудитад аймаг, сумын Сонгуулийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Цагдаагийн газар болон холбогдох бусад байгууллагуудын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн зардлыг хамрууллаа.

**Аудитын
арга зүй,
шалгуур
үзүүлэлт**

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашигласан.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Хууль:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль;
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам.
- Батлагдсан төсөв, төсвийн хуваарь.

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

Аудитыг аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Г.Энх-Амгалан, аудитор Б.Ариунаа нар хийж гүйцэтгэв.

Хүндрэл
бэрхшээл

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс гүйцэтгэн, аудитыг гүйцэтгэх ажлыг 7 дугаар сарын 08-аас 7 дугаар сарын 22-ны өдрүүдэд, тайлагналын үе шатыг 7 дугаар сарын 25-ны дотор дуусган, аудитын тайлан, судалгааг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2024 оны 7 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт хүргүүлэв.

Сонгуулийн хэсгийн хороодын нягтлан бодогчид ээлжийн амралт авсантай холбоотойгоор аудитыг гүйцэтгэхэд хугацаа алдах хүндрэл үүсэж байв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн Улсын Их Хурлын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 6-р тойрог, 18 сум, 89 хэсгийн хороо, мэдээлэл технологийн 1 багийн 5 ажилтан, нийт 89 даамал, нөөц 20 даамал, улсын бүртгэлийн 96 итгэмжлэгдсэн ажилтан, цагдаагийн 137 албан хаагч ажиллахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг аймгийн сонгуулийн хорооны төсөвт 911,512.6 мянган төгрөг, аймгийн Цагдаагийн газрын төсөвт 56,782.0 мянган төгрөг, Улсын бүртгэлийн хэлтсийн төсөвт 82,990.9 мянган төгрөг, нийт 1,051,285.5 мянган төгрөгийг баталсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн сонгуулийн хороонд бүрэн олгосон байна.

БҮЛЭГ 1

**Сонгуулийн хороодод төсвийг хууль, журмын дагуу
төлөвлөж хуваарилсан байна.**

**1.1.1 Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах
зардлын төсвийг журмын дагуу боловсруулж батлуулсан байна.**

Хэнтий аймгийн Сонгуулийн хорооноос Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын төсвийн төслийг Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлээгүй байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын даргын 2024 оны А/45 дугаар тушаалын хавсралтаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны төсвийг 911,512.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор төсвийн төслийг холбогдох газар, нэгж, байгууллагын саналыг авч үндэслэлтэй төлөвлөх нь зүйтэй байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос дээрх төсвийг аймгийн Сонгуулийн хороонд бүрэн олгосон байна.

Хүснэгт 1: Батлагдсан төсөв зардлын ангиллаар

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Зөрүү
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	300.0	300.0	-
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	41,164.5	41,164.5	-
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	3,430.0	3,430.0	-
4	Дүн мэдээ дамжуулах зардал	-	-	-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	27,590.0	27,590.0	-
6	Сургалт, сурталчилгааны зардал	37,027.3	37,027.3	-
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	664,668.0	664,668.0	-
8	Бичиг хэргийн зардал	14,380.0	14,380.0	-
9	Шуудан холбооны зардал	17,050.0	17,050.0	-
10	Унааны зардал	73,570.0	73,570.0	-
11	Албан томилолтын зардал	12,216.0	12,216.0	-
12	Болзошгүй зардал	20,116.9	20,116.9	-
13	Нэмэлт Хяналтын тооллого хийсэн нийслэл, дүүрэг, хэсгийн хорооны гишүүдийн хоолны зардал	-	-	-
14	Нэмэлт Хяналтын тооллого хийсэн хэсгийн хорооны унааны зардал	-	-	-
15	Саналын хуудас устгах зардал	-	-	-
НИЙТ ДҮН		911,512.6	911,512.6	-

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хороонд батлагдсан төсөв, хуваарилалт

Монгол улсын Сонгуулийн хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасны дагуу төсвийг хуваарилсан байна.

1.1.2 Аймгийн Сонгуулийн хорооноос сумдын Сонгуулийн хороодод төсвийг журмын дагуу хуваарилсан байна.

Аймгийн Сонгуулийн хорооны даргын 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 24 дүгээр захирамжаар сумын Сонгуулийн хороодод төсөв хуваарилсан нь холбогдох журам, заавар, аргачлалд нийцсэн байна.

Хүснэгт 2: Сумдын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.

/мянган төгрөг/

№	Сумдын нэр	Сумдад хуваарилсан төсөв	Аудитаар тооцсон төсөв	Зөрүү
	аймаг	159,476.8	159,476.8	-
	Дүн	159,476.8	159,476.8	-
1	Галшар	43,329.4	43,329.4	-
2	Баянхутаг	23,870.7	23,870.7	-
3	Баянмөнх	36,211.5	36,211.5	-
4	Дархан	37,136.5	37,136.5	-
5	Дэлгэрхаан	43,267.4	43,267.4	-
6	Жаргалтхаан	38,254.5	38,254.5	-
7	Цэнхэрмандал	31,753.0	31,753.0	-
8	Өмнөдэлгэр	59,499.4	59,499.4	-
9	Батширээт	35,881.2	35,881.2	-
10	Биндэр	38,451.6	38,451.6	-
11	Баян-Адарга	35,784.5	35,784.5	-
12	Дадал	37,539.7	37,539.7	-
13	Норовлин	33,334.0	33,334.0	-
14	Батноров	49,577.6	49,577.6	-
15	Баян-Овоо	35,820.6	35,820.6	-
16	Мөрөн	36,755.8	36,755.8	-
17	Хэрлэн	90,967.8	90,967.8	-
18	Бор-Өндөр	44,600.6	44,600.6	-
	Сумдын дүн	752,035.8	752,035.8	-
	НИЙТ	911,512.6	911,512.6	-

Эх сурвалж: Аймгийн сонгуулийн хорооны даргын 2024 оны 24 дүгээр захирамж

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3-т заасан зардлуудыг аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороодын төсөвт хуваарилсан байна.

1.1.3 Улсын бүртгэлийн ерөнхий газар нь сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс зардлын ангиллыг баримтлах боломжгүй болсон байна.

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/24 тоот тушаалаар батлагдсан төсвөөр Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 78,470.9 мянган төгрөг, тодотголоор 4,520.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 82,990.9 мянган төгрөг хуваарилагдаж ирсэн боловч төсвийг тодотгон баталсан тушаалыг ирүүлээгүй байна.

Урамшууллыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр олгохоор гэрээ байгуулсан боловч 510.0 мянган төгрөгөөр бодож олгосон, орон нутгаас ирсэн, очсон унааны зардлыг бүх сумдыг

нэг тарифаар буюу 14.0 мянган төгрөгөөр тооцож төсвийг баталсан нь Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг бодитой төлөвлөөгүй байна.

2. Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албаны 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн 16/1983 тоот албан бичгээр Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон хамгаалалтын зардлын төсвийг баталсан байна.

Хүснэгт 3: Цагдаагийн газарт баталсан төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Хоол хүнс	30,072.0	30,072.0	-
2	Шуудан холбоо	13,910.0	13,910.0	-
3	Тээвэр шатахуун	2,000.0	2,000.0	-
4	Томилолт	10,800.0	10,800.0	-
НИЙТ		56,782.0	56,782.0	-

Эх сурвалж: Хэнтий аймгийн Цагдаагийн газрын төсвийн гүйцэтгэл

БҮЛЭГ 2

Сонгуулийн хороод сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

1.2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын 2024 оны 3/229, 3/290, 3/373, 3/472, 3/562 тоот албан бичгээр ирүүлсэн төсвийн зориулалтын тайлбарт заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийг зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 3: Батлагдсан төсөв, гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар.

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	300.0	300.0	-
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	41,164.5	41,163.2	1.3
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	3,430.0	3,430.0	-
4	Дүн мэдээ дамжуулах зардал	-	-	-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	27,590.0	27,590.0	-
6	Сургалт, сурталчилгааны зардал	37,027.3	36,883.6	143.6
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээлэл технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	664,668.0	664,646.2	21.8
8	Бичиг хэргийн зардал	14,380.0	14,379.8	0.2
9	Шуудан холбооны зардал	17,050.0	17,050.0	-
10	Унааны зардал	73,570.0	73,570.0	-
11	Албан томилолтын зардал	12,216.0	12,201.7	14.3
12	Болзошгүй зардал	20,116.9	16,054.7	4,062.2
13	Нэмэлт Хяналтын тооллого хийсэн нийслэл, дүүрэг, хэсгийн хорооны гишүүдийн хоолны зардал	-	-	-
14	Нэмэлт Хяналтын тооллого хийсэн хэсгийн хорооны унааны зардал	-	-	-

15	Саналын хуудас устгах зардал	-	-	-
НИЙТ ДҮН		911,512.6	907,269.2	4,243.4

Эх сурвалж: Хэнтий аймгийн Сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан төсвөөс 907,269.2 мянган төгрөгийг зарцуулж 4,243.4 мянган төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд төвлөрүүлсэн байна.

Хэнтий аймгийн Сонгуулийн хороо, сумдын Сонгуулийн хороодын сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлын зарцуулалтыг төсвийн гүйцэтгэлийн мэдээ, дансны хуулга, зардлын тайлан, анхан шатны баримтуудтай тулган шалгахад холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшууллыг 1,207.8 мянган төгрөгөөр хэмнэж, сонгогчдын нэрсийн жагсаалтыг хэвлэх, хүргэхэд шаардагдах зардлыг 106.6 мянган төгрөг, сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлыг 96.0 мянган төгрөг, сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал, томилолтын зардлыг 1,005.0 мянган төгрөгийг тус тус хэтрүүлэн зарцуулж, зардлын ангиллыг баримтлаагүй байна. Мөн нэг өдрийн томилолтын зардлыг Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар батлагдсан зардлын хэмжээгээр тооцож олгоогүйгээс нийт 4,680.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг сонгуулийн хороодын ажилтнуудад дутуу олгосон байна.

Хүснэгт 4: Улсын бүртгэлийн хэлтсийн батлагдсан төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөг/

№	Зардлын ангилал	Зардлын ангилал	Нийт батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардлын төсөв	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны мөнгөн урамшуулал	4,800.0	3,137.6	1,662.4
		Итгэмжлэгдсэн болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал	49,747.5	50,202.1	(454.6)
2	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардлын төсөв	Сонгогчдын нэрийн жагсаалтыг зардал	3,617.4	3,600.0	17.4
		Сонгогчдын нэрийн жагсаалтыг хороодод хүргэх зардал	1,772.0	1,896.0	(124.0)
3	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардлын төсөв	Томилолт, унааны зардал	11,748.0	11,930.0	(182.0)
		Сургалтын бусад зардал	6,320.0	6,234.0	86.0
		Сургагч багшийн зардал	-	-	-
4	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	Томилолтын зардал	1,136.0	2,141.2	(1,005.2)
		Тээврийн зардал	3,400.0	3,400.0	-
		Шуурхай багийн зардал	450.0	450.0	-
		ДҮН	-	82,990.9	82,990.9

Эх сурвалж: Улсын бүртгэлийн хэлтсийн зардлын судалгаа

1.2.2. Сонгуулийн хороод зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Аймаг, сумын Сонгуулийн хороод нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар батлагдсан “Сонгуулийн

төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтаар сонгуулийн зардлын тайлангаа гаргасан байна.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар бодитой тайлагнасан эсэхийг шалгахад зөрчил илрээгүй.

Аймгийн Цагдаагийн газарт хуваарилсан Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлыг хянан үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газар нь сонгууль зохион байгуулахтай холбогдсон хамгаалалтын төсвийн зарцуулалтын тайланг 2024 оны 7 дугаар сарын 02-ны 51/3204 албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, ар талын албанд хүргүүлсэн байна.

Сонгуулийн байр тохижуулах зардлаас худалдан авсан эд материалын зүйлс, сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн материаллаг шинжтэй хөрөнгийг аймгийн Засаг даргын тамгын газар, сумдын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгч, тухайн байгууллагууд бараа материалд бүртгэн хүлээж авсан байна.

1.2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Сонгуулийн хорооны дарга сонгуулийн хорооны зардлын гүйлгээний баримт дээр нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч хоёрдугаар гарын үсгийг зурж баталгаажуулан ажилласан байна.

Хэнтий аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороонд зардлын санхүүжилт, зардлын гүйцэтгэлийн аргачлал, зөвлөмж, чиглэлийг тухай бүр хүргүүлэн хяналт тавьж ажилласан байна.

Сонгуулийн хороодод нэгдсэн журмаар Төрийн санд түр данс нээж, зардлын гүйлгээнд аймаг, сумын Төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж баталгаажуулан ажилласан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Аймаг сумын Сонгуулийн хороодод төсвийг хууль, журмын дагуу хуваарилсан байна.
- Улсын бүртгэлийн ерөнхий газраас сонгууль зохион байгуулахтай холбоотой төсвийг үндэслэлтэй тооцож ирүүлээгүй байна.
- Аймаг сумын Сонгуулийн хороод зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

ҮАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах саналыг ҮАГ-т хүргүүлж байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газар нь сонгууль зохион байгуулах зардлын төсвийг томилолтын зардал, унааны зардал, итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн урамшуулал зэргийг тогтоосон хэмжээнээс бага, аймаг сумдын хоорондын зайг тооцоогүй зэргээр үндэслэлгүй төлөвлөсөн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ХЭНТИЙ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

Чингис хот, Хэрлэн сум, Хэнтий аймаг, 23119
Утас, Факс: 7056 2401

2024.07.30 № 58

танай 2024.07.30-ны № 713 -т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБААТАР ТАНАА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулсан аймгийн сонгуулийн хорооны санхүүгийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн төслийг хүлээн зөвшөөрч байна.



ДАРГА

Ж.ГАНТУЛГА

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 07 дугаар сарын 30

Дугаар А/31

Чингис хот

Г Нийцлийн аудитын тайлан Г
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл” сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт, аймгийн сонгуулийн хорооны дарга (Ж.Гантулга) нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэхийг ахлах аудитор (Г.Энх-Амгалан)-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

202410050